

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга
хэмжээний 86.4 хувийг бүрэн гүйцэтгэж, гэрээг
дүгнэж хүлээн авсан байна.

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-02-ШТА-НА

Хөвсгөл аймаг
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
А.Эрдэнэбаатар
Аудитын менежер
Б.Тэгшдэлгэр
Ахлах аудитор
З.Даваадорж
Аудитор
Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

2025 оны 04 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүйгээс 8,394.7 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөсөн байна.

1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 80.7 хувийг шалгуурын дагуу бүрэн үнэлээгүй, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй байна.

1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг төсөлтэй байх шаардлагыг хангаагүй 3, хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлыг тооцоогүй 22 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.4. Тухайн шатны төсөвт байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх боломжтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Бүлэг 2: Тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч буюу яамдаас зураг төсөл нь батлагдаагүй 3 төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна.

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийн 39%-ийг захиалагч буюу аймгийн Засаг дарга батлаагүй байна.

2.3. Тендерийн баримт бичигт заасан заасан шалгуурыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Бүлэг 3: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 86.4%-тай байна.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

3.2. Тайланд онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 86.4 хувийг бүрэн хэрэгжүүлж, гэрээг дүгнэж хүлээн авсан байна.

3.3. Тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлсэн эсэхийг хүлээж авах ажлын хэсэгт тухай бүр мэргэжлийн чиглэлийн албан хаагчдыг оролцуулан хүлээн авсан байна.

3.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 4,380.4 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох төсөвт байгууллагуудад эзэмшүүлэх шийдвэр гаргаж бүртгэлд тусгасан байна.

4.1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 89.4 хувьтай байна.

Дүгнэлт

Зөвлөмж
Зөрчлийн жагсаалт
Тайлангийн хавсралтууд
Холбогдох байгууллагуудын санал

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨА	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХШҮХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ХАА	Худалдан авах ажиллагаа



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/12

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагуудыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын дарга нарт хүргүүлсүгэй.

3. “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” нийцлийн аудитын зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн биелэлтийг 2025 оны 12 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу), Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Э.Азаяа), Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ын захирал (Д.Батчулуун) нарт даалгасугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 1/12 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт нийцлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

д/д	Акт, албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Акт, албан шаардлагын дугаар
1	Зөрчил арилгуулах тухай	Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс	83/A2270437/ГНАГ-2025/06-02-ШТА-НА
2	Сахилгын хариуцлага тооцуулах тухай	Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	84/A2270437/ГНАГ-2025/06-02-ШТА-НА
3	Зөрчил арилгуулах тухай	Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ	85/A2270437/ГНАГ-2025/06-02-ШТА-НА
4	Зөрчил арилгуулах тухай	Хөвсгөл аймгийн Худалдан авах ажиллагааны газар	86/A2270437/ГНАГ-2025/06-02-ШТА-НА

--ooOoo--

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, МУЕА-ын баталсан төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөсөн эсэх
- ❖ Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- ❖ Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх
- ❖ Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хугацаанд хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад 2024 онд эрх шилжин хэрэгжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар Санхүү, төрийн сангийн хэлтэс, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон хяналтын чиг үүрэг бүхийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв, Алаг-Эрдэнэ, Хатгал, Рэнчинлхүмбэ, Цагааннуур, Улаан-Уул, Баянзүрх, Арбулаг, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Түнэл, Эрдэнэбулган сумдын холбогдох төрийн байгууллага, ажлын хэсгийн үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын хязгаарлалт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн ТЕЗ-д эрх шилжсэн 26 төсөл, арга хэмжээг хамруулан үзсэн болно. Барилгын ажил зогсдог улиралд аудитын гүйцэтгэж байгаатай холбогдуулан улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжсэн хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилтийг байдлыг бодит байдлыг газар дээр нь үзэж шалгах боломжгүй байлаа.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-400-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дугаар тушаалаар баталсан ТАБ-ын “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглав.

Хөвсгөл аймгийн ТЕЗ-д эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн

Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд үндэслэн аудитын дүгнэлт, шийдвэрийг боловсруулсан болно.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Хөвсгөл аймагт 2024 онд улсын төсвөөс **456,093.3** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Үүнээс: Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргад 38,550.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна. Эрх шилжсэн хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 35,434.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 нь шинээр, 3,116.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ өмнөх оноос шилжиж хэрэгжсэн байна.

Эрх шилжин хэрэгжсэн 29 төсөл арга хэмжээний санхүүжилтэд 2024 онд 17,706.3 сая төгрөг олгохоор төлөвлөж гүйцэтгэлээр 11,222.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Тайлант онд олгохоор төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэлийг хөрөнгө оруулалтын төрлөөр нь ангилан харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1 /сая төгрөг/

№	Төрөл	Тоо	Төсөвт өртөг	2024 онд олгох санхүүжилт	2024 онд олгосон санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэл /хувиар/
1	Барилга байгууламж	16	31,546.7	12,019.3	6,088.2	50.6 %
2	Тоног төхөөрөмж	12	6,923.7	5,607.0	5,009.2	89.3 %
3	Их засвар	1	80.0	80.0	Санхүүжилтийн эрх шилжиж ирээгүй	0 %
Нийт дүн		29	38,550.4	17,706.3	11,097.4	69.9%

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламжийн төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 69.9%-тай байгаа нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсөвгүй төсөл арга хэмжээг улсын төсөвт тусгаснаас шалтгаалсан байна.

БҮЛЭГ 1:

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙГЭЭС 8,394.0 САЯ ТӨГРӨГИЙН 3 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгсэн төсөл арга хэмжээг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжсэн 26 төсөл арга хэмжээний төлөвлөлтийн уялдааг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №2

№	Шалгуур	Уялдсан төсөл арга хэмжээний тоо	Уялдуулаагүй төсөл арга хэмжээний тоо	Уялдсан төсөл арга хэмжээ /хувь/
1	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр /УИХ-ын 2020 оны 23-р тогтоол/	7	19	27%
2	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө /УИХ-ын 2023 оны 39-р тогтоол/	1	25	4%
Улсын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдсан дундаж				15.5%
3	Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр /ИТХ-ын 2015 оны 02 дугаар тогтоол/	14	12	54%
4	Хөвсгөл аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө /ИТХ-ын 2023 оны 05 дугаар тогтоол/	23	3	88%
Аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдсан дундаж				71%

Улс болон аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний аль альтай нь уялдуулан төлөвлөсөн дараах 6-н төсөл арга хэмжээ байна. **Үүнд:**

- Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/
- Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/
- Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн ном Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/ фонд, тоног төхөөрөмж /Хөвсгөл/
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний автомашин /Хөвсгөл/
- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Хөвсгөл/
- Хөдөөгийн сумдын харилцаа холбооны тоног төхөөрөмж /Хөвсгөл/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 15.5 хувь нь улсын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй, 71.0 хувь нь аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдсан байдлаас харахад орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа ч улсын хөгжлийн үзүүлэлтийг хангах хэмжээд төлөвлөөгүй байдал ажиглагдаж байна.

1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 80.7 хувийг шалгуурын дагуу бүрэн үнэлээгүй, нийгэм, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй байна.

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх ажлыг цахимаар гүйцэтгэж эхэлсэн байна.

Хөвсгөл аймагт 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр эрх шилжиж ирсэн 26 төсөл арга хэмжээнээс 21 төсөл арга хэмжээ буюу 80.7 хувийг шалгуурын дагуу бүрэн үнэлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжихээр эрх шилжиж ирсэн 26 төсөл арга хэмжээнээс 22 төсөл арга хэмжээний Нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдлыг тооцоогүй байна.

1.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зураг төсөлтэй байх шаардлагыг хангаагүй 3, хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлыг тооцоогүй 22 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 26 төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ шаардахгүй төсөл арга хэмжээ байна. Батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолттой байх шаардлага хангасан байдлыг ангилан хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3

Ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Зураг, төсөв техникийн тодорхойлолтгүй	Хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоогүй
Барилга байгууламж	14	3	19
Тоног төхөөрөмж	11	0	0
Их засвар	1	0	0
Дүн	26	3	19

Шинээр хэрэгжихээр эрх шилжин ирсэн 26 төсөл арга хэмжээнээс 19 төсөл арга хэмжээ хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоолол хийгээгүй байна.

Зураг, төсөвтэй байх төлөвлөлтийн шаардлага хангаагүй 8,394.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ байна. **Үүнд:**

- Ахмадын өргөөний барилга /Улаан-Уул, Эрдэнэбулган сум/ төсөвт өртөг 960.0 сая төгрөг
- Нийтийн халуун усны барилга / Бүрэнтогтох сум/ / төсөвт өртөг 576.0 сая төгрөг
- Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал / Цагаан-Үүр сум/ төсөвт өртөг 6,858.0 сая төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх,санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2² дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хөрөнгийн ашиглалттай холбоотой орон тоо, урсгал зардлын тооцоог хийгээгүйгээс хөрөнгийн ашиглагч, цаашид эзэмшиж өмчлөх байгууллага нь тодорхойгүй болсон тохиолдлыг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт №4 /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Ашиглалтад хүлээн авсан огноо	Шалтгаан, нөхцөл
1	Нийтийн ариун цэврийн байгууламж	139.9	2022	Улсын төсвийн хөрөнгө бий болсон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлын санхүүжилтийг урьдчилж тооцоогүйгээс тухайн ариун цэврийн байгууламжийн ашиглалтын зардалгүй.
2	Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор	5,170.0	2024	Төсөл арга хэмжээг Шинэ-Мөрөн худалдааны төвд хүлээлгэж өгсөн боловч аймгийн Хөгжимт драмын театр хариуцаж байна. Тухайн цогцолборын харуул хамгаалалтын зардлыг төлөвлөөгүй.

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй.

Төсөл арга хэмжээний хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлыг тооцоогүйгээс тухайн хөрөнгө ашиглалтгүй орхигдох эрсдэлийг дагуулж байна.

1.4. Тухайн шатны төсөвт байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх боломжтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуульд зааснаар хөрөнгө оруулалт нь тухайн шатны ашиглагч байгууллагын өмчлөлд шилжих боломжтой байх ёстой. Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүд нь ашиглагч байгууллагын өмчлөлд бүртгэх боломжтой эсэхэд хяналт хийхэд нийт эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүд нь дээрх шаардлагыг хангаж байна үзлээ.

Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн эсэхэд хяналт хийхэд дараах төсөл, арга хэмжээнүүд хэмнэлтийн хуульд нийцээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 5 /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хориглосон заалт	Хэрэгжилт
1	Сумын төвийн авто зам /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	757.0	13.4.3.орон нутгийн авто замын засвар хийх;	Хэрэгжээгүй
2	Ахмадын өргөөний барилга /Улаан-Уул, Эрдэнэбулган сум/	960.0	13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.	Хэрэгжээгүй
3	Нийтийн халуун усны барилга /Бүрэнтогтох сум/	576.0		Хэрэгжээгүй
4	Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал	6,858.0		Хэрэгжээгүй
Нийт дүн		9,151.0		

Өмнөх оноос шилжиж хэрэгжсэн 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр Багц-7” төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.4³ дэх заалтыг зөрчсөн гэж үзэн Сангийн яамнаас төлбөрийн хүсэлтийг баталгаажуулаагүй тул санхүүжилтийг олгоогүй байна.

Тус төсөл арга хэмжээ нь 2022 оноос хэрэгжиж эхэлсэн тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2⁴-т заасан хязгаарлалтад хамаарахгүй байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар тухайн шатны төсөвт байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэж болох хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

³ 13.4.4.багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах;

⁴ Энэ хуулийн 13.3, 13.4 дэх хэсэг улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны төсвийн жилээс эхлэн шинээр тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хамаарна.

БҮЛЭГ 2: ТЕНДЕРИЙН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГТ ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАСАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛСАН БАЙНА.

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч буюу яамдаас зураг төсөл нь батлагдаагүй 3 төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Хөвсгөл аймгийн хэмжээнд шинээр хэрэгжих 26 төсөл арга хэмжээнээс 29,941.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байна. Төрийн худалдан авах ажиллагааны газарт 5,492.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд эрх шилжин хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/06 дугаар захирамжаар баталж, тендер зарлах огноог 2024.01.15-ны өдрөөр тогтоосон боловч төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүй байна.

Холбогдох яамдаас аймгийн Засаг дарга эрх шилжүүлэхдээ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1⁵-д заасан хугацааг баримтлаагүй эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал. *Хүснэгт № 6*

№	Холбогдох яамд ТЕЗ	Төсөл арга хэмжээний нэр	Эрх шилжүүлэх огноо	Эрх шилжүүлсэн огноо	ХАА зарласан огноо	Гэрээ байгуулах эрх олгосон огноо
1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/	2024.01.20	2024.02.02	2024.04.05	2024.05.01
2	Боловсролын яам	Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж	2024.01.20	2024.02.23	2024.05.15	Хэрэгжээгүй
3	Эрчим хүчний яам	5.1. Баянзүрх сумын төвөөс "Бошлой хад" хүртэлх 11 км 10 кв-ын ЦДАШ	2024.01.20	2024.01.31	2024.06.21	2024.09.05
		5.2. Чандмань-Өндөр сумын Доншиг чиглэлд 35 кв-ын ЦДАШ, дэд станц		2024.01.31	2024.03.22	2024.07.01
		5.3 Тээл багийн цахилгаан хангамж		2024.01.31	2024.11.20	2024.12.02

Төсвийн ерөнхийлөн захирагч буюу яамдаас зураг төсөл нь батлагдаагүй 3 төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн байна. *Хүснэгт № 7 /сая төгрөг/*

№	ТЕЗ	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Эрдэнэбулган сум/	960.0
2	Барилга, хот байгуулалтын яам	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	576.7
3	Боловсролын яам	Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	6,858.0
Нийт дүн			8,394.7

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 заалттай нийцэхгүй байна.

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна:

Төсвийн тухай хуулийн тодотголоор 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр нэмэгдсэн 2 төсөл арга хэмжээг аймгийн Засаг дарга эрх шилжүүлсэн байна. **Үүнд:**

- Сумын төвийн авто зам /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/
- Уурын зуухны халаалтын тогоо, 2 ширхэг /Хөвсгөл, Их-Уул сум/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих эрх шилжсэн 26 төсөл арга хэмжээнээс 24 төсөл арга хэмжээг 42 багц болгон 75 удаа тендер шалгаруулалтыг зохион байгуулж 27 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж нийт 439.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна.

Хууль болон журамд заасны дагуу төсөвт өртгийг үндэслэн зохион байгуулах журмыг сонгосон байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэлбэрийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №8 /сая төгрөг/

ХАА-д мөрдсөн журам	Төсөл арга хэмжээний тоо	ХАА зохион байгуулсан тоо	ХАА-ны үр дүнд хүрсэн тоо	Төсөвт өртөг	Гэрээ байгуулсан дүн	Тендерийн хэмнэлт
Нээлттэй	20	57	18	23,237.6	19,848.2	400.9
Харьцуулалт	3	14	2	204.5	103.9	0.6
Ерөнхий гэрээ /цахим дэлгүүр/	1	4	1	157.2	118.9	38.3
Нийт дүн	26	75	23	23,599.3	20,071.0	439.8

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Журамд заасан хугацаа хоцроож эрх шилжүүлсэн 3 төсөл арга хэмжээ болон Төсвийн тухай хуулийн тодотголоор 2 төсөл арга хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан аймгийн Засаг дарга Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй.
2. Аймгийн Засаг даргын 2024 оны А/06 дугаар захирамжаар баталсан 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан худалдан авах ажиллагааг зарлах хугацааг баримтлаагүй.
3. Зураг төсөвгүй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан /Ахмадын өргөөний барилга Улаан-Уул, Эрдэнэбулган сум/

Энэ нь Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам" 2.17⁶ дахь заалттай нийцэхгүй байна. Дээрх зөрчилд холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Зураг төсөв нь батлагдаагүй 8,394.7 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн тул худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломж бүрдээгүй, төсөл арга хэмжээний эрх шилжүүлэхдээ хууль тогтоомжид заасан хугацааг баримтлаагүй тул тогтоосон хугацаанд худалдан авах ажиллагааг зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулах боломж бүрдээгүй байгаа зэргээс харахад хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангахгүй байна.

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийн 39%-ийг захиалагч буюу аймгийн Засаг дарга батлаагүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хороо нь жишиг баримт бичгийг баримтлан тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулж захиалагчаар батлуулахаар холбогдох хууль тогтоомжид заасан байна.

⁶ Хуулийн 45.2-т заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгаврыг ирүүлээгүй, илтэд алдаатай, эсхүл бүрэн бус ирүүлсэн бол мэргэжлийн байгууллага ажлын гурван өдрийн дотор захиалагчид мэдэгдэж, төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг холбогдох баримт бичиг бүрэн ирүүлэх хүртэл хугацаагаар зарлахыг түдгэлзүүлнэ."

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 21 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг” баримтлан боловсруулсан байна.

Дараах 2 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль журамд нийцүүлэн боловсруулаагүй байна. Үүнд:

1. Загас үржүүлгийн баазын тоног төхөөрөмж /Хөвсгөл, Цагааннуур сум/:

- Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтын 10 дахь хэсэгт тусгасан "Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, төслийн угсралт, зүгшрүүлэлт, мониторинг хийх" ажлыг 215.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр тусгасан байна. Хуульд заасны дагуу техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах "Бараа" буюу тоног төхөөрөмжид "ажил" буюу "зөвлөх үйлчилгээ"-ний төсөл арга хэмжээг тусган тендерийн баримт бичгийг боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
- Тендерийн баримт бичигт барааг хүлээн авах газрын байршлыг Тендер шалгаруулалтын заавар болон Гэрээний тусгай нөхцөлд өөр өөрөөр заасан байна.

2. Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Эрдэнэбулган сум/ төсөл арга хэмжээг зураг төсөв нь батлагдаагүй байхад тендерийн баримт бичигт тусган худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 24 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгээс аймгийн Засаг дарга 8 тендерийн баримт бичиг, аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга 14 тендерийн баримт бичгийг баталж албажуулсан байна. Диаграммаар харуулбал дараах байдалтай байна.



Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1⁷ дэх заалттай нийцэхгүй байна. Тус зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Үнэлгээний хороод нь тендерийн баримт бичиг боловсруулахдаа Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа нийцүүлэн ашиглаж байна.

2.3. Тендерийн баримт бичигт заасан шалгуурыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерийг нээх, хянан үзэх, үнэлж захиалагчид зөвлөмж хүргүүлэн гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгосон байна.

Худалдан авах ажиллагаанд оролцогчдын ирүүлсэн тендерийг хууль журамд нийцүүлэн үнэлж тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан эсэхийг хуульд заасан шалгуураар үнэлж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/ төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг БА-6.1, БА-6.2, БА-6.3, БА-6.4 тусгай

⁷Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

зөвшөөрөлтэй байхыг шаардсан боловч тендерт шалгарсан "Жигүүр ой" ХХК нь БА-6.2⁸, БА-6.3⁹ зөвшөөрөлтэй байх шалгуурыг хангахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4¹⁰ “26 дугаар зүйлийн 26.4¹¹, 26.9¹² дэх заалттай нийцээгүй бөгөөд хуульд заасан шалгуурыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

БҮЛЭГ 3:	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 86.4%-ТАЙ БАЙНА.
-----------------	--

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шилжих хөрөнгө оруулалт 3, шинээр хэрэгжих 26 төсөл арга хэмжээ, нийт 29 төсөл арга хэмжээг 38,550.4 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн ба 2024 онд 17,706.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан байна.

Тайлант онд эрх шилжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд 11,237.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. *Хүснэгт № 9 сая төгрөг*

№	Эрх шилжүүлсэн ТЕЗ	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	2024 онд санхүүжих дүн	Олгосон санхүүжилт	Санхүүжилт гүйцэтгэл
Өмнөх оноос шилжиж хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын санхүүжилт							
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1	1,411.3	808.4	593.1	548.2	92.4%
2	Барилга хот байгуулалтын яам	1	641.2	641.2	285.2	0	-
3	Эрүүл мэндийн яам	1	1,063.5	-	447.1	316.3	70.7%
Нийт дүн		3	3,116.0	1,449.6	1,325.4	864.5	54.4%
Тайланд онд шинээр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын санхүүжилт							
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	5	9,113.0	8,901.8	4,152.0	2,731.7	65.8%
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	3	1,890.0	1,885.1	1,570.0	1,166.2	74.3%
3	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2	1,640.0	167.3	632.0	167.3	26.5%
4	Барилга хот байгуулалтын яам	1	1,730.1	570.0	519.0	233.0	44.9%
5	Боловсролын яам	3	7,438.0	478.8	2,438.0	478.8	19.6%
6	Соёлын яам	2	4,110.0	4,064.0	1,300.0	1,259.6	96.9%
7	Эрчим хүчний яам ¹³	3	1,688.4	1,573.8	1,688.4	1069.5	63.3%
8	Эрүүл мэндийн яам	3	5,334.0	5,171.7	2,080.6	1,407.4	67.6%
9	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	1	910.0	905.1	910.0	905.1	99.5%

8 БА-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, хөргөх байгууламж, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
9 БА-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт зэрэг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй байна.
¹⁰ Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.”
¹¹ Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ
¹² Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ
¹³ Эрчим хүчний яамнаас эрх шилжин хэрэгжиж буй төсөл арга хэмжээний 348.0 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн.

10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2	823.9	814.4	823.9	814.4	98.8%
11	Зам, тээврийн яам	1	757.0	Гүйцэтгэгч шалгараагүй	267.0	0	0
Нийт дүн		26	29,942.0	24,532.0	16,380.9	10,233.0	59.7%
Бүгд дүн		29	33,058.0	25,981.6	17,706.3	11,097.5	57.0%

Эрх шилжиж хэрэгжиж буй төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 57.0 хувьтай байгаа нь тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд зохион байгуулах боломж бүрдээгүй, оролцогч ороогүй, зураг төсөлгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй зэргээс шалтгаалан ажил оройтож эхэлсэнтэй холбоотой байна.

Тайланд онд хэрэгжихээр төсөв батлагдсан боловч санхүүжилт олгогдоогүй төсөл арга хэмжээг тайлангийн хавсралт № 1 харуулав. Санхүүжилт олгогдоогүй төсөл арга хэмжээний харахад төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ шилжиж ирснээс шалтгаалан худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсантай холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг олгосон санхүүжилттэй харьцуулан графикаар харуулбал. *График №1*



Тайланд онд бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг хүлээн авах ажлын хэсэг, комисс актаар хүлээн авч, тус актыг үндэслэн гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн ажлын гүйцэтгэлд 10,429.0 сая төгрөг, зураг төсвийн зардалд 200.4 сая төгрөг, техникийн хяналтад 106.1 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 42.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, барьцаа хөрөнгийн дансанд 808.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн 808.1 сая төгрөгийн 348.0 төгрөг нь 3 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт болгон төвлөрүүлсэн байна.

3.2. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 86.4 хувийг бүрэн хэрэгжүүлж, гэрээг дүгнэж хүлээн авсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр ТЕЗ-д эрх шилжиж ирсэн 29 төсөл арга хэмжээний 15 төсөл арга хэмжээг 2024 онд, 4 төсөл арга хэмжээг 2025 онд, 7 төсөл арга хэмжээг 2026 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

Тайланд онд бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг төсөл арга хэмжээний ангиллаар хүснэгтээр харуулбал. *Хүснэгт №11 /сая төгрөг/*

№	Ангилал	Төсөвт өртөг	Төсөл арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжиж дуусаагүй /хувь/	Огт хэрэгжээгүй	Хэрэгжилтийн дундаж хувь
Өмнөх оноос шилжиж хэрэгжиж буй							
1	Барилга байгууламж	1,704.1	2	1	1	-	50 %
2	Тоног төхөөрөмж	1,411.3	7	7	-	-	100%
Дүн		3,115.4	9	8	1	-	88.9%
Тайланд онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн							

1	Барилга байгууламж	2,738.4	6	4	1	1	66,7%
2	Тоног төхөөрөмж	4,513.9	17	15	1	1	88.2%
3	Их Засвар	80.0	2	2	-	-	100%
Дүн		7,332.2	25	21	2	2	84.0%


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж хэрэгжиж буй Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/ төсөл арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэгч гэрээнд заасан хугацааг баримтлан гүйцэтгээгүй байна.

Иймд тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээс гэрээнд заасны дагуу алданги тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

График №2

Төсвийн тухай хуульд 2024 онд хэрэгжүүлэхээр заасан 15 төсөл арга хэмжээний 34 багц арга хэмжээний гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Графикаас харахад шилжих хөрөнгө оруулалтаас 1 арга хэмжээ, шинээр хэрэгжих 4 арга хэмжээ төсвийн тухай хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй байна.



Хугацаандаа хэрэгжээгүй 5 арга хэмжээг авч үзэхэд дараах шалтгаантай байна.

Хүснэгт №12 /сая төгрөг/

№	Хугацаандаа хэрэгжээгүй төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг	2024 оны гүйцэтгэл /%/	Шалтгаан, нөхцөл
1	Нийтийн халуун усны барилга /Хөвсгөл, Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум/	641.2	80%	Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй.
2	Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж	100.0	0	Боловсролын яамнаас баталж ирүүлсэн Техникийн тодорхойлолтоос шалтгаалан тендерийг түдгэлзүүлсэн.
3	Уурын зуухны халаалтын тогоо, 2 ширхэг /Хөвсгөл, Их-Уул сум/	320.0	50 %	Гэрээний хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн. /Шүүхэд хянагдаж байна./
4	5.1. Баянзүрх сумын төвөөс "Бошлой хад" хүртэлх 11 км 10 кв-ын ЦДАШ	900.0	78 %	9-р сард гэрээ байгуулж 12 сард дуусгахаар төлөвлөсөн боловч давагдашгүй хүчин зүйл тулгарсан.
5	5.3 Тээл багийн цахилгаан хангамж" (Тосонцэнгэл сум)	24.5	0	Зураг төсөл 2024.11.14-нд батлагдаж тендер шалгаруулалт оройтож, 12 сард гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж 2025 оны 04 дүгээр сард дуусгахаар төлөвлөсөн.
Нийт дүн		1,985.7	41.6 %	

Тайланд онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний гүйцэтгэл 86.4 хувьтай байгаа хэдий ч Төсвийн тухай хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөснөөс тендер шалгаруулалтыг оройтож зарласантай холбоотой байна.

3.3. Тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлсэн эсэхийг хүлээж авах ажлын хэсэгт тухай бүр мэргэжлийн албан хаагчдыг оролцуулан хүлээн авсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 53 багц арга хэмжээний 24 арга хэмжээ нь барилга байгууламж, 27 арга хэмжээ нь тоног төхөөрөмж, 2 арга хэмжээ нь их засвар байна.

Тайланд онд хэрэгжсэн 25 арга хэмжээг захиалагч техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлсэн эсэхийг хүлээж авах ажлын хэсэг тухай бүр мэргэжлийн чиглэлийн албан хаагчдыг оролцуулан акт үйлдэж хүлээн авсан байна.

Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлд захиалагч, зохиогч нь Барилгын тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажиллахаар зохицуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламжийн ажлын үе шатны хяналтыг Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4¹⁴ дэх заалтыг үндэслэн Хөвсгөл аймгийн Барилга, захиалагчийн хяналтын төв ААТҮГ-т шилжүүлж, тухайн хяналтыг төлөөлүүлэн хэрэгжүүлсэн байна.

Тайланд онд хэрэгжсэн дараах төсөл арга хэмжээг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй байна. Үүнд:

1. Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/ төсөл арга хэмжээний “Гадна хашаа хайс”-ын тулгуур шонг зураг төсөлд 2 метрийн урттай 80х80 мм хэмжээтэй квадрат багана байхаар төлөвлөсөн боловч 1.7 метр урттай 50х50 мм хэмжээтэй квадрат төмөр ашигласан бөгөөд зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд барилга бүтээц, зураг төсөлд орсон өөрчлөлтгүй гэж дүгнэсэн. Иймд зөрүү дүн болох 3,072,400 төгрөгийг барьцаа хөрөнгөөс суутгах албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв.

Тус төсөл арга хэмжээний зургийг “Онч Тэнхлэг” ХХК гүйцэтгэсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 21-нд Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийгдсэн байна.

2. Бэлчээрийн усан хангамж төсөл арга хэмжээний хүрээнд Мөрөн, Бүрэнтогтох, Их-Уул, Рашаант, Эрдэнэбулган суманд баригдах худгийн барилга байгууламжийн хэмжээ нь БА-2 зурагт заасны дагуу тэнхлэгээрээ 3.5х4 метр, таазны өндөр шалны түвшнээс 2.8 метр байхаар төлөвлөсөн боловч дээрх 5-н худгийн барилгыг тэнхлэгээрээ 3х3 метр, таазны өндрийг 2.3 метрийн өндөртэйгөөр барьсан байна.

Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн 2024.11.15-ны өдрийн НД-152/2024 нэгдсэн дүгнэлтэд худгийн барилгыг тэнхлэгээрээ 3х3 метр, таазны өндрийг 2.3 метрийн өндөртэйгөөр барьсан гэж дүгнэсэн боловч Зураг төсөлд орсон өөрчлөлтөд зохиогчоос зөвшөөрөл аваагүй байна.

Зохиогч “Амдо наяд” ХХК-аас 2024.05.25-ны өдөр барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийж гаргасан дүгнэлтэд тус барилга байгууламжийн арагт бүтээцийн хэмжээнд орсон өөрчлөлтийн талаар дурдаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд мөн 37.1.5¹⁵-д заалттай нийцэхгүй байна. Зураг төсөлд орсон өөрчлөлт бүрийг тухай бүр зохиогчоос зөвшөөрөл авч ажлыг үргэлжлүүлэх тус алдааг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх зөрчил нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжийн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийг чиг үүргийг гүйцэтгэж буй Барилга, захиалагчийн хяналтын төв нь хуульд заасны дагуу барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналтыг хийлгэх ажлыг бодитоор зохион байгуулаагүйтэй холбоотой байна.

¹⁴ барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах;

¹⁵ барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах;

3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 4,380.4 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох төсөвт байгууллагуудад эзэмшүүлэх шийдвэр гаргаж бүртгэлд тусгасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх шийдвэрийг тухай бүр гаргасан байна.

Тайланд онд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар 4,189.6 сая төгрөгийн дүнтэй 1,256 ширхэг тоног төхөөрөмжийг 94 төрийн байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэсэн төрийн байгууллагыг салбар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 13 /сая төгрөг/

№	Төрийн байгууллага	Тоног төхөөрөмжийн тоо	Бүртгэсэн дүн	Бүртгэлд тусгаагүй дүн
1	Аймаг, сумдын ЗДТГ	992	1,690.5	-
2	Эрүүл мэндийн байгууллага	101	1,252.0	-
3	Соёлын салбарын байгууллага	94	259.6	-
4	Боловсролын байгууллага	6	478.8	-
5	Галт Дулаан ОНӨХХК	27	95.0	-
6	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	24	5.6	-
7	Байгаль орчны газар	11	-	408.1
8	Монголын цахилгаан холбоо ХК Хөвсгөл аймгийн Холбооны газар	47747	-	905.0
Нийт дүн		49002	3,781.5	1,313.1

Загас үржүүлгийн баазын тоног төхөөрөмж /Хөвсгөл, Цагааннуур сум/ төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг аймгийн ОНӨГ-ын даргын 2024 оны А/45 дугаар тушаалаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт 10 төрлийн 12 ширхэг нийт 623.6 сая төгрөгийн хөрөнгийг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн боловч бүртгэлд тусгаагүй байна.

Мөн тус төсөл арга хэмжээний хүрээнд 215.5 сая төгрөгийн дүн бүхий “Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх төслийн угсралт, зүгшрүүлэлт, мониторинг” зардлыг холбогдох данс бүртгэлд тусгах зөвлөмж хүргүүлэв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 5-н төсөл арга хэмжээний хүрээнд ашиглалтад хүлээн авсан 2,868.2 сая төгрөгийн 10 барилга байгууламж бий болсон байна. Тус хөрөнгийг бүртгэлд тусгасан байдлыг хүснэгтээр харуулбал. Үүнд:

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Ашиглалтад хүлээн авсан огноо	Бүртгэлд тусгасан дүн
1	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	1,063.5	2024.12.23	0.
2	Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/	1,170.0	2024.07.31	0
3	Уурын зуухны шинэчлэл /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	96.5	2024.10.26	0
4	5.2. Чандмань-Өндөр сумын Доншиг чиглэлд 35 кв-ын ЦДАШ, дэд станц	347.4	2024.12.23	0
5	Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл/	200.0	2024.11.23	190.8
Дүн		2877.4		190.8

Хүснэгтээс харахад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 2,686.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээ бүртгэлд тусгаагаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх,

данснаас хасах, шилжүүлэх” журмын 4.4¹⁶, 4.5¹⁷-д дахь заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон барилга байгууламжийг бүртгэлд тусгаагүй нь аймгийн Засаг даргаас үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлдэгтэй холбоотой хүлээгдэж байна

4.1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 89.4 хувьтай байна.

Өмнөх оны аудитаар 1 төлбөрийн акт, 8 албан шаардлага, 8 зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн актын биелэлт 100%, албан шаардлагын биелэлт 75%, зөвлөмжийн биелэлт 93.3% байна.

Аудитаар албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг дахин хянахад дараах албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Үүнд:

- 1. Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвд хүргүүлсэн албан шаардлага:** Төрийн аудитын газрын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 78/A2270438/ХӨА-2024/28-21-ШТА-ГА дугаартай “Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын ахмадын төвийн барилгын ажлыг гэрээнд заасан хугацаанд, зураг төслийн дагуу гүйцэтгүүлээгүй, Чандмань-Өндөр сумын ахмадын төвийн барилгын шат, суурийн хаяавчид хагарал өгсөн” Зөрчил арилгах албан шаардлагыг биелэлттэй танилцахад өмнөх зөрчлийг арилгаагүй байна.
- 2. Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвд хүргүүлсэн зөвлөмж:** Төрийн аудитын газраас хүргүүлсэн “Зураг, төсөв, техникийн шаардлагын дагуу гүйцэтгээгүй ажлуудын зөрчлийг арилгуулах, захиалагчийн хяналтын үр нөлөөг сайжруулах.” Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй бөгөөд өмнөх онд гарсан зөрчил давтагдсан байна. Үүнд:
 - Аялал жуулчлалын "Соёмбо" цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/ төсөл арга хэмжээний “Гадна хашаа хайс”-ын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй.
 - Бэлчээрийн усан хангамж төсөл арга хэмжээний хүрээнд Мөрөн, Бүрэнтогтох, Их-Уул, Рашаант, Эрдэнэбулган суманд баригдах худгийн барилга байгууламжийг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй.
 - Өмнөх онд хэрэгжсэн “Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдын ахмадын төвийн барилгын ариутгах татуургын гадна шугамын ажил, бохир усны цооногийн ажил /V=10м3/-ыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй.

¹⁶ Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана

¹⁷ Улсын комисс барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн захиалагч байгууллага болон Төсвийн ерөнхийлөн захиарагчаас тухайн үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлснээр эзэмшигч байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 15.5 хувь нь улсын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй, 71.0 хувь нь аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдсан байдлаас харахад орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа ч улсын хөгжлийн үзүүлэлтийг хангах хэмжээд төлөвлөөгүй байдал ажиглагдаж байна.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжихээр эрх шилжиж ирсэн 26 төсөл арга хэмжээнээс 22 төсөл арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдлыг тооцоогүйгээс барилга байгууламж ашиглалтгүй орхигдох эрсдэлийг дагуулж байна.
3. Зураг төсөв нь батлагдаагүй 8,394.7 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн тул худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломж бүрдээгүй, төсөл арга хэмжээний эрх шилжүүлэхдээ хууль тогтоомжид заасан хугацааг баримтлаагүй тул тогтоосон хугацаанд худалдан авах ажиллагааг зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулах боломж бүрдээгүй байгаа зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангахгүй байна.
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайланд онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл 86.4%-тай бөгөөд санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 3,999.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй нь аймгийн Засаг даргаас үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлдэгтэй холбоотой хүлээгдэж байна.
6. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарч байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийн ашиглалтыг сайжруулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх
2. Тендер шалгаруулалтын баримт бичгийг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд батлах.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэст:

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг шалгуурын дагуу бүрэн үнэлж, хөрөнгийн ашиглалтай холбоотой урсгал зардлын тооцоолол хийж байх.
4. Улс төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлтийг Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцүүлэн боловсруулах
5. Улсын төсвийн хөрөнгөөр 2022 оноос шилжин хэрэгжиж ашиглалтад хүлээн авсан зарим төсөл арга хэмжээний санхүүжилтийг одоо болтол олгоогүй байгааг анхаарч, холбогдох арга хэмжээг авч ажиллах
6. Техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах "Бараа" буюу тоног төхөөрөмжид "ажил" буюу "зөвлөх үйлчилгээ"-ний төсөл арга хэмжээг тусган тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байхад анхаарч ажиллах

Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

7. Аймгийн Засаг даргын баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулах.
8. Тендерийн баримт бичигт барааг хүлээн авах газрын байршлыг Тендер шалгаруулалтын зааварчилгаа болон гэрээний тусгай нөхцөлд тодорхой тусгах
9. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа зураг төсөлгүй багцыг тендерийн баримт бичигт оруулахгүй байх, зураг төсөв дутуу, техникийн тодорхойлолт илтэд алдаатай бол холбогдох журам зааврын дагуу буцааж зөрчлийг арилгаж ажиллах

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт:

10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Загас үржүүлгийн баазын тоног төхөөрөмж /Хөвсгөл, Цагааннуур сум төсөл төсөл арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг аймгийн ОНӨГ-ын даргын 2024 оны А/45 дугаар тушаалаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн боловч бүртгэлд тусгаагүй байна.
11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжсэн "Уурын зуухны шинэчлэл" төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг УСНББОУС-ыг баримтлан бүртгэлд тусгах
12. Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг холбогдох журам зааврыг баримтлан хуулийн этгээдэд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах.

Зөрчлийн жагсаалт:

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталж, эрх шилжүүлсэн.	8,394.0					1	8,394.0
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээг төлөвлөсөн.	757.0					1	757.0
3	Өмнөх оноос шилжиж хэрэгжсэн хүлээн авсан төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.	20.0					1	20.0
4	Зураг төсөвт заасан материалын тоо хэмжээг бууруулж, үнийн зөрүүг бий болгосон.	3.1			1	3.1		
5	2022 онд ашиглалтад хүлээн авсан Нийтийн ариун цэврийн байгууламжийг одоог хүртэл ашиглаж эхлээгүй байна.	139.9					1	139.9
6	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүй байна.	-					1	-
7	Журамд заасан хугацаа хоцроож эрх шилжүүлсэн, төсвийн тодотголоор нэмэгдсэн төсөл арга хэмжээг 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж тодотгол хийгээгүй.	-					1	-
8	Зураг төсөвгүй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан /Ахмадын өргөөний барилга Улаан-Уул, Эрдэнэбулган сум/	-					1	-
9	Тендерийн баримт бичигт барааг хүлээн авах газрын байршлыг Тендер шалгаруулалтын заавар болон Гэрээний тусгай нөхцөлд өөр өөрөөр заасан байна.	-					1	-
10	Техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах "Бараа" буюу тоног төхөөрөмжид "ажил" буюу "зөвлөх үйлчилгээ"-ний төсөл арга хэмжээг тусган тендерийн баримт бичгийг боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	215.5					1	215.5
11	Засаг дарга холбогдох журамд заасны дагуу тендерийн баримт бичгийг бүрэн баталгаажуулж ажиллаагүй байна.	-					1	-
12	Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.	-			1	-		
13	Төсөл арга хэмжээг зураг төсөлд заасны дагуу бүрэн гүйцэтгээгүй,	-			1	-		

	зохиогчоос зөвшөөрлийг тухай бүр авах ажлыг зохион байгуулаагүй.							
14	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	3,083.1					1	3,083.1
15	Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжүүлээгүй, зөрчил дахин давтагдсан байна.	-			1	-		
НИЙТ ДҮН		12,612.6	-	-	4	3.1	11	12,609.5

Санхүүжилт олгогдоогүй төсөл арга хэмжээ

№	ТЕЗ	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилт олгогдоогүй шалтгаан
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр /Хөвсгөл, Галт сум/	Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулсан бөгөөд Гүйцэтгэгчтэй 2024.12.04-ны өдөр гэрээ байгуулж барилгын ажлыг эхлүүлээгүй.
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/	Тендерийг 2024.02.29-ны өдрөөс хойш багц тус бүрийг 5-6 удаа зохион байгуулж Багц-1,3-ын гүйцэтгэгчтэй 2024.09.17-ны, Багц-2-н гүйцэтгэгчтэй 2024.11.08-ны өдөр тус тус гэрээ байгуулж барилгын ажлыг эхлүүлээгүй.
3		Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын байгууллагуудын их засвар /Улсын хэмжээнд/	Санхүүжилтийн эрх шилжиж ирээгүй.
4	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Эрдэнэбулган сум/	Худалдан авах ажиллагаанд оролцогч шалгараагүй. (Зураг төсөлгүйгээс шалтгаалан 2024.11.28-нд тендер зарласан)
5	Барилга хот байгуулалтын яам	Нийтийн халуун усны барилга / Бүрэнтогтох сум/	Зураг төсөлгүй.
6		Нийтийн халуун усны барилга / Шинэ-Идэр сум/	Худалдан авах ажиллагаанд оролцогч шалгараагүй.
7	Боловсролын яам	Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	Зураг төсөлгүй.
8		Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж /Хөвсгөл/	ХАА-г эрх бүхий байгууллагаас түдгэлзүүлсэн.
9	Зам, тээврийн яам	Сумын төвийн авто зам /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	Худалдан авах ажиллагаанд оролцогч шалгараагүй.

--ooOoo--